



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 13 өдөр

Дугаар А/3552

Номгон

Баянхонгор аймагт хийгдсэн "110/35/10 кВ-ын Баянхонгор дэд станцын Өргөтгөл, шинэчлэл /Баянхонгор/" төсөл арга хэмжээний 110/35/10 кВ-ын 16МВТ-ын трансформатор секц 1-ийг 10 кВ-руу шилжүүлэх үеийн ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5 дахь заалт, Эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хийгдсэн дэд станцын өргөтгөлийн ажлыг хэсэгчилж хүлээж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

С.Хүрэлхуяг Газрын харилцаа, Барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга

Гишүүд:

Б.Анхбаяр "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" Төрийн өмчит ХК-ийн хангайн бүсийн салбарын ерөнхий инженер

Б.Бадамцэцэг "Баянхонгор-Эрчим хүч" Цахилгаан түгээх ХХК-ний ерөнхий инженер

А.Ганбат "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" Төрийн өмчит ХК-ийн хангайн бүсийн салбарын Баянхонгор дэд станцын ахлах инженер

Э.Батбаяр "Баясалтөгс" ХХК-ийн ерөнхий инженер

Ч.Галбадрах "ДМТМ ТРЕЙД" ХХК-ийн ерөнхий инженер

Нарийн бичгийн дарга:

А.Ганбаатар "Эрчим хүчний үндэсний төв" Төрийн өмчит ХК-ийн Захиалагч, Техник хяналтын хэлтэс, Цахилгааны хяналтын ахлах инженер


642311437

2.

2.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хийгдсэн дэд станцын өргөтгөлийн ажлыг хэсэгчилж хүлээж авах ажлыг хэрэгжүүлж илэрсэн зөрчлийг арилгуулах, техникийн бичиг баримтыг бүрдүүлэн акт үйлдэж өмчлөлд бүртгүүлж хүлээн авахыг ажлын хэсгийн дарга (С.Хүрэлхуяг)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН